



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/504

Чингис хот

Эд хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2-ын "а" "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 60 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянмөнх сумын Засаг даргын Тамгын газрын 3 929 700 төгрөгийн балансын үнэтэй, 3 929 700 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үлдэх өртөггүй 2 айлын орон сууцыг газар эзэмших эрхийн хамт худалдсугай.

2. Худалдах эд хөрөнгийг хавсралтаар баталсугай.

3. Худалдах хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Н. Үнэнбат

Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Хөтлөгч:

С.Энхцэцэг

Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Л.Оюунтуяа

Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч, Бичиг хэрэг

Өмч эзэмшигч байгууллагын төлөөлөл

4. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр 12:00 цагт Баянмөнх сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулсугай

5. Эд хөрөнгийг худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Үнэнбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010857

Аймгийн Засаг даргын 2020 оны
 10 дугаар сарын 30-ны өдрийн
 7/504 дугаар захирамжийн хавсралт

ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Худалдах үнийн санал			
										Байгууллагын санал	Орон нутгийн газрын санал	Хурлын шийдвэр	Үүнээс Аймгийн төсөвт
1	Баянмөнх сум ЗДТГазар	Орон сууц	2006.11.17	4*7	1	1,964,850	1,964,850	1,964,850	-	3,000,000	4,300,000	3,264,850	3,264,850
		Орон сууц	2006.11.17	4*7	1	1,964,850	1,964,850	1,964,850	-	3,000,000	4,300,000	3,264,850	3,264,850
Нийт дүн					2	-	3,929,700	3,929,700		6,000,000	8,600,000	6,529,700	6,529,700